



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2021 оны 10-р сарын
13-ны өдөр

№ 21/01

Сайншанд хот

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 430, 2016 оны 179 дүгээр тогтоол, Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө, аймгийн Засаг даргын "Хөгжлийн төлөө хамтдаа" 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сайншанд сумын Эдийн Засаг нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл зэргийг үндэслэн нэг талаас "Эм Жи Эл Гео Хүдэр ХХК"-ийг төлөөлж төсөл хариуцсан захирал Г.Мөнхсүлд /цаашид аж ахуйн нэгж гэх/ Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын Тамгын Байгаль орчин, Уул уурхай, Ашигт малтмалын бодлого хариуцсан мэргэжилтэн Т.Ганмөнх /цаашид ЗДТГ гэх/, нөгөө талаас нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь талууд байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, газрын тос, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа, ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааг тогтвортой, хэвийн, байгаль орчинд сөрөг нөлөөгүй явуулах, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг мөрдөж ажиллах, тулгамдсан асуудлуудад харилцан ойлголцох, нэгдсэн саналд хүрч хоёр талын цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэн байгальд зэлтэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд энэхүү гэрээний гол зорилго оршино.

1.2. Тусгай зөвшөөрөл өзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

1.3. Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвллийн тухай, Газрын тосны тухай, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.

Хоёр. Засаг даргын тамгын газрын эрх, үүрэг

2.1. Ашигт малтмалын олборлолт, боловсруулах үйлдвэрлэл явуулах, ашигт малтмал эрэх, хайх, нөхөн сэргээх хугацаанд тус компанид, хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлж, бүх чиглэлээр хяналт тавьж ажиллана.

2.2. Аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар мэргэшсэн ажилтан бэлдэхэд дэмжлэг үзүүлнэ

2.3. Шинэ ажлын байр нэмэгдүүлж буй ажил олгогчийг урамшуулан дэмжинэ

2.4. Сум, орон нутгийн хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээлнэ

Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг бүхий л хэлбэрээр дэмжинэ.

- 2.5. Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг ААНБ-д сурталчилна
- 2.6. Татварын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох саналыг хамтран хүргүүлнэ.
- 2.7. Аж ахуйн нэгжийн зүгээс ирүүлсэн санал хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх, хариу өгөх.
- 2.8. Орон нутагт охин компани байгуулах, орон нутагт харьяалалтай болоход нь дэмжлэг үзүүлж, шийдвэрлэж өгөх үүрэг хүлээнэ.

Гурав. Аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

- 3.1.Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөгөөр батлагдсан талбайд хайгуул, олборлолт явуулах.
- 3.2.Нийгмийн даатгал болон Татварын ерөнхий хуулийн дагуу орон нутгийн албан татвар, шимтгэлийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлж, татварын өр төлбөргүй ажиллана.
- 3.3.Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах хугацаанд Улсын бүртгэлийн хуулийн этгээдийн салбарын гэрчилгээ авч, ашиглаж байгаа тээврийн хэрэгсэл, хүнд даацын техникийг орон нутгийн дугаартай болгоно.
- 3.4. Газрын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн газар ашиглах эрхийг баталгаажуулна
- 3.5. Ашигт малтмал олборлох, тээвэрлэх, эрэл хайгуулын үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулна
- 3.6 Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэнэ
- 3.7. Уулын болон хайгуулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллана
- 3.8.“Ногоон төгөл-Ногоон байгууламж” уриан дор ашигт малтмал тутамд нэг ширхэг мод тарих, орон нутгийн ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.9.Үйл ажиллагааны явцад тусгай зөвшөөрөлтэй талбайд орших түүх, соёлын дурсгалт зүйл, булаг шанд бүхий газрыг хөндөхгүй, хамгаалах үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 3.10.Хайгуулын үйл ажиллагааны явцад түр хугацаагаар ажиллах туслах ажилтныг сүм, орон нутгаас авч ажиллуулна
- 3.11.Ажиллагсдыг эрүүл мэндийн шинжилгээнд бүрэн хамруулна
- 3.12.Уул уурхайн болон ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааг сүм, орон нутгийн иргэдэд сурталчилна
- 3.13.Ажилчдын хувцас, хэрэглэл болон хүнсний бүтээгдэхүүнийг өөрийн хайгуул, олборлолтын талбай байрлах сүм, орон нутгийн иргэд, нөхөрлөл, оёдолчдоос авах болон гэрээгээр захиалж хийлгэх.
- 3.14.Орон нутагтай ус ашиглах болон хог хаягдлын гэрээ байгуулж ажиллана.
- 3.16.Мэргэжилтэй ажилчин, хүний нөөцийг бэлтгэх захиалга өгөх, орон нутагт сургаж бэлтгэх.
- 3.15.Ажилчдын нийгмийн асуудалд анхаарч эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах.
- 3.16.Орон нутгийн ажиллах хүч, зуучлалын албан тушаалтан, байгууллагатай хамтарч ажиллах.

Дөрөв. Хамтран хүлээх үүрэг

- 4.1. Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачлага гаргаж ажиллана
- 4.2. Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно

Тав. Гэрээг дүгнэх

5.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийг 2021 оны 12-р сард дүгнэнэ

Зургаа. Гэрээний хариуцлага

- 6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.
- 6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Долоо. Маргаан шийдвэрлэх

- 7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдоо шүүхэд гаргаж болно.

Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

- 8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш НЭГ жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ
- 8.2. Давтагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.
- 8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.
- 8.4. Гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

А тал

“Эм Жи Эл Гео Хүдэр” ХХК-ний
төлөөлж захирал
..... (Г.Мөнхсүлд)
Утас: 99005552
Хаяг: УБ хот: СБ дүүрэг, ЧӨЧ
Email: 4-р байр, А блок 202 тоот
Gunbaa@yahoo.com

Б тал

Сайншанд сумын Засаг даргын Тамгын
газрын Байгаль орчны бодлогын
мэргэжилтэн (Т.Ганмөнх)
Утас: 70523167
Хаяг: Сайншанд сум 3-р баг
Нутгийн удирдлагын ордон
ganmunkh2018@gmail.com